



**“ЕВРАЗИА КАПИТАЛ ХОЛДИНГ ҮЦК” ХК  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН**

**ТОГТООЛ**

2025 оны 3-р сарын 26 өдөр

Дугаар:25/02/01

Улаанбаатар хот

**ТУЗ-ИЙН ДҮГНЭЛТ, ТӨЛӨВЛӨГӨӨ БАТЛАХ ТУХАЙ**

Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.9 дэх заалт, 2025 оны 3-р сарын 26-ны өдрийн тооллогын комиссын 25/01/02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг баталсугай.
2. Компанийн 2025 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бизнес төлөвлөгөө болон компанийн үйл ажиллагааг цаашид хэвийн явуулахад шаардлагатай бусад төсөл төлөвлөгөөг батлан зөвшөөрсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



Р.ОТГОНБАТ





**“ЕВРАЗИА КАПИТАЛ ХОЛДИНГ ҮЦК” ХК  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН**

**ТОГТООЛ**

2025 оны 3-р сарын 26 өдөр

Дугаар:25/02/02

Улаанбаатар хот

**НОГДОЛ АШИГ ХУВИАРЛАХГҮЙ  
ТУХАЙ ШИЙДВЭРИЙГ ТАЙЛАГНАХ НЬ**

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.2, 46.6-р заалтууд, 2025 оны 3-р сарын 26-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 25/01/02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Тус компани нь ашигтай ажиллаагүй тул ногдол ашиг хувиарлахгүй гэж шийдвэрлэсэн тухай хувьцаа эзэмшигч нарт тайлагнасан болохыг дурьдсугай.

ХУРЛЫН ДАРГА



Р.ОТГОНБАТ



**“ЕВРАЗИА КАПИТАЛ ХОЛДИНГ ҮЦК” ХК  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН**

**ТОГТООЛ**

2025 оны 3-р сарын 26 өдөр

Дугаар:25/02/03

Улаанбаатар хот

**КОМПАНИЙН ДҮРЭМД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

Компанийн тухай хуулийн 18, 20 дугаар зүйлүүд, 2025 оны 3-р сарын 26-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 25/01/02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор таван тэрбум хүртлэх төгрөгийн үнийн дүн бүхий энгийн хувьцааг нэмж гарган уг шийдвэрийг Санхүүгийн Зохицуулах Хороо хянан зөвшөөрсөний дараа компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулсугай.
2. Хувьцаа нэмж гаргахтай холбоотой үнэ тогтоох, холбогдох төлөвлөгөө, дүгнэлтүүдийг батлах, шаардах эрх хэрэгжүүлэх эрхийг компанийн ТУЗ-д олгосугай.
3. Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг хавсралтаар баталсугай.
4. Компанийн дүрэмд орсон өөрчлөлтийг холбогдох эрх бүхий байгууллагад бүртгүүлэхийг Гүйцэтгэх Захиралд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Р.ОТГОНБАТ



**“ЕВРАЗИА КАПИТАЛ ХОЛДИНГ ҮЦК” ХК  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН**

**ТОГТООЛ**

2025 оны 3-р сарын 26 өдөр

Дугаар:25/02/04

Улаанбаатар хот

**КОМПАНИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭГ  
НЭМЭГДҮҮЛЭХ, НЭМЭЛТ ХУВЬЦАА ГАРГАХ ТУХАЙ**

Компанийн тухай хуулийн 31, 42 дугаар зүйлүүд, 2025 оны 3-р сарын 26-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 25/01/02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компани нь нээлттэй хувьцаат компанийн хувьд үнэт цаасны зах зээлд брокер, дилер, андеррайтер, хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа явуулахад Санхүүгийн Зохицуулах Хорооны холбогдох журамд заасан зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангах шаардлагатай байгаа тул хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг таван тэрбум хүртэл төгрөгөөр нэмэгдүүлэхийг зөвшөөрсүгэй.
2. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэхдээ олон нийтэд болон хаалттай хүрээнд, стратегийн хөрөнгө оруулагчдад нэр заан эзэмшүүлэхээр таван тэрбум хүртэл төгрөгийн үнийн дүн бүхий энгийн хувьцааг нэмж гарган уг шийдвэрийг Санхүүгийн Зохицуулах Хороо хянан зөвшөөрсөний дараа компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулсугай.
3. Хувьцаа нэмж гаргахтай холбоотой үнэ тогтоох, холбогдох төлөвлөгөө, дүгнэлтүүдийг батлах, шаардах эрх хэрэгжүүлэх эрхийг компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлд олгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Р.ОТГОНБАТ





**“ЕВРАЗИА КАПИТАЛ ХОЛДИНГ ҮЦК” ХК**  
**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН**  
**ТОГТООЛ**

2025 оны 3-р сарын 26 өдөр

Дугаар:25/02/05

Улаанбаатар хот

**ТЭРГҮҮН ЭЭЛЖИНД ХУВЬЦАА ЭЗЭМШҮҮЛЭХ**  
**ЭРХ ЭДЛҮҮЛЭХ ЭСЭХ ТУХАЙ**

Компанийн тухай хуулийн 62.1.8, 38 дугаар зүйлүүд, 2025 оны 3-р сарын 26-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 25/01/02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор таван тэрбум хүртлэх төгрөгийн үнийн дүн бүхий энгийн хувьцааг олон нийтэд болон хаалттай хүрээнд, стратегийн хөрөнгө оруулагчдад нэр заан эзэмшүүлэхээр нэмж гаргахтай холбоотойгоор одоогийн хувьцаа эзэмшигчдэд тэргүүн ээлжинд хувьцаа худалдан авах эрхийг эдлүүлэхгүй байхаар шийдвэрлэсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



Р.ОТГОНБАТ



**“ЕВРАЗИА КАПИТАЛ ХОЛДИНГ ҮЦК” ХК**  
**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН**  
**ТОГТООЛ**

2025 оны 3-р сарын 26 өдөр

Дугаар:25/02/06

Улаанбаатар хот

**КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН**  
**ГИШҮҮДИЙГ СОНГОХ ТУХАЙ**

Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.7 заалт, 2025 оны 3-р сарын 26–ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 25/01/03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Кумулятив аргаар санал хураасан дүнг үндэслэн дараах нэр бүхий зургаан хүнийг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр сонгосугай.

1. САЙНБОЛОР Мягмар
2. ХАЛИУНАА Ганчимэг
3. САИДАБРОР Рустамходжаев
4. КАМОЛИДДИН Талипов
5. ЭНХБАТ Гомбо
6. САРАНТУЯА Цэвэгсүрэн

2. Кумулятив аргаар санал хураасан дүнг үндэслэн дараах нэр бүхий гурван хүнийг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр сонгосугай.

1. БОЛОРМАА Цэрэнгомбо
2. ДИЛДОРА Али
3. САОДАТ Умарова

3.Компанийн тухай хууль болон дүрмээр тогтоосон үүргээ хэрэгжүүлж, компанийн эрх ашгийн төлөө ажиллахыг гишүүдэд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Р.ОТГОНБАТ